



2026 оны 02 сар 13 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5, 46.6 дахь заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2.8 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.9, 8.12 дахь заалт, Ногдол ашгийн журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Говь ХК-ийн 2025 оны санхүүгийн үр дүн нь компанийн ногдол ашгийн бодлогын 2.3-т заасан ногдол ашиг олгох нөхцөлийг хангаагүй буюу санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул компанийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Компанийн ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн үндэслэлийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр тайлагнахыг Гүйцэтгэх захирал (Б.Амарсайхан)-д даалгасугай.
3. Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн тухай мэдээллийг зохих журмын дагуу эрх бүхий байгууллага болон олон нийтэд хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (М.Сэлэнгэ)-д даалгасугай.

ТУЗ-ийн дарга   Ц.БААТАРСАЙХАН



2016 он 01 сар 13 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Компанийн дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх тухай

Говь ХК-ийн Дотоод аудитын хэлтэс нь толгой компанийн бүтэц, удирдлагад шилжсэнтэй холбогдуулан нээлттэй хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хяналтын чиг үүргийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, дотоод хяналтын тогтолцооны хараат бус байдал, үр ашигтай ажиллагааг хадгалах, компанийн засаглалын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалтыг удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Говь ХК-ийн Дотоод аудитын хэлтэс нь зохион байгуулалтын хувьд толгой компанийн бүтэц, удирдлагад харьяалагдах боловч аудитын үйл ажиллагааны тайлагнал, хараат бус хяналт нь ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороонд харьяалагдах болохыг баталгаажуулсугай.
2. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо нь компанийн дотоод хяналтын чиг үүргийг дараах байдлаар хэрэгжүүлсүгэй. Үүнд:
 - Дотоод аудитын жилийн ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах;
 - Компанийн эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан аудитын тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох;
 - Дотоод аудитын тайлангийн үр дүнтэй тухай бүр танилцаж, аудитын зөвлөмж, үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих;
 - Дотоод аудитын хэлтэст шаардлагатай үүрэг даалгавар өгөх, хэрэгцээ шаардлагын дагуу захиалгат аудит хийлгэх;
 - Улирал тутам хорооны хурлын хүрээнд Гүйцэтгэх удирдлага болон толгой компанийн төлөөлөлгүйгээр Дотоод аудитын хэлтэстэй уулзалт хийж, хараат бус байдлыг ханган ажиллах;
 - Шаардлагатай үед гаднын хараат бус аудитын байгууллагаар нэмэлт хяналт хийлгэх эрхтэй байна.
3. Дээрх эрх, үүргийн хүрээнд хорооны үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулж, ТУЗ-өөр батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрсдэл, аудитын хорооны дарга (А.Жаргалмаа)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, компанийн хэмжээнд дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэн ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Амарсайхан)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ц.БААТАРСАЙХАН



2026 он 02 сар 13 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэлд зөвшөөрөл олгох тухай

Говь ХК-ийн 2025 оны 4-р улирлын сонирхлын зөрчилтэй хэлцлийн гүйцэтгэлийг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2.7.15 дахь заалт, Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмын 3 дугаар зүйлийн 3.3.1, 3.3.2 дахь заалтыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

- Говь ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 03-р сарын 20-ны өдрийн №07 тоот тогтоолоор 2025 онд компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдахыг зөвшөөрсөн сонирхлын зөрчилтэй буюу нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн жагсаалт болон төсвийг баталсныг дурдсугай.
- ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны 2026 оны 02-р сарын 05-ны ээлжит хурлаар дээрх батлагдсан тогтоолын хэрэгжилттэй танилцан хяналт тавьсан бөгөөд дараах төсөвт тусгагдаагүй бараа, ажил үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр хийгдсэн болохыг хүлээн зөвшөөрч, баталгаажуулсугай. Үүнд:

№	Компанийн нэр	Бараа, үйлчилгээ	Үнийн дүн /төгрөг/
1	Таван Богд Нура ХХК	Мэдээлэл технологийн үйлчилгээ	891,875,600
2	Таван Богд Билдинг Саплай ХХК	Хоол үйлдвэрлэлийн үйлчилгээ	1,024,002,000
3	Ю Би Пи ХХК	Хэвлэх үйлчилгээ	78,500,000
4	Таван Богд Холдингс ХХК	Түрээсийн үйлчилгээ	170,000,000
5	Gobi Cashmere Korea ХХК	Барааны борлуулалт	515,045,775
	Нийт		2,679,423,375

- Дээрх хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Д.ХҮРЭЛБААТАР



2026 он 02 сар 13 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

**2026 онд сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийгдэх
хэлцэлд зөвшөөрөл олгох тухай**

Говь ХК-ийн 2026 онд сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийгдэх хэлцлийг хэлэлцсэний үндсэн дээр Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2.7.15 дахь заалт, Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмын 3 дугаар зүйлийн 3.3.1.1 дэх заалтыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Говь ХК нь 2026 онд компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах, зээлийн шугамын гэрээ байгуулахыг зөвшөөрсөн сонирхлын зөрчилтэй буюу нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн жагсаалтыг Хавсралт 1-ээр баталсугай.
2. 2026 онд Нэгдмэл сонирхолтой этгээдүүдтэй хийх сонирхлын зөрчилтэй хэлцлийн төсвийг Хавсралт 2-оор баталсугай.
3. Хавсралт 1-д заагаагүй сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх болон Хавсралт 2-д баталсан төсвөөс хэтэрсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тохиолдолд тухай бүр Төлөөлөн Удирдах Зөвлөлд мэдэгдэж, Компанийн тухай хуулийн 76.1.17, 92 дугаар зүйлд заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл авч байхыг Гүйцэтгэх захирал (Б.Амарсайхан)-д үүрэг болгосугай.
4. Дээрх сонирхлын зөрчил бүхий этгээдүүдтэй хийгдэх хэлцэл нь батлагдсан төсвийн хүрээнд, зах зээлийн үнээр, хуулийн дагуу хийгдэж байгаа эсэх дээр улирал бүрийн хорооны хурлаар дамжуулан хяналт тавьж ажиллахыг Эрсдэл, аудитын хорооны дарга (А.Жаргалмаа)-д үүрэг болгосугай.
5. Жилийн эцэст сонирхлын зөрчил бүхий этгээдүүдтэй хийгдсэн ажил гүйлгээний гүйцэтгэлийг гарган, зах зээлийн үнийн харьцуулсан судалгааны хамт Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Амарсайхан)-д үүрэг болгосугай.
6. Энэхүү асуудлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД




Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Д.ХҮРЭЛБААТАР

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2026 оны 02 сарын 13-ны өдрийн хурлын
09-р тогтоолын 1-р хавсралт



2026 онд бараа, үйлчилгээг зах зээлийн үнээр худалдан авах, худалдах,
зээлийн шугамын гэрээ байгуулахыг зөвшөөрсөн сонирхлын зөрчилтэй буюу
нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн жагсаалт

1. Таван Богд Группийн охин компаниуд

Д/д	Компанийн нэрс	Д/д	Компанийн нэрс
1	Таван Богд Холдингс ХХК	9	Хаан Палас ХХК
2	Таван Богд Интернэйшнл ХХК	10	Таван Богд Фүүдс ХХК
3	Таван Богд Нура ХХК	11	Таван Богд Фүүдс Пицца ХХК
4	Таван Богд Финанс ББСБ ХХК	12	Ю Би Пи ХХК
5	Таван Богд ХХК	13	Таван Богд Капитал ҮЦК ХХК
6	Эйрлинк Монголиа ХХК	14	Таван Богд Билдинг Саплай ХХК
7	Улаанбаатар Гурил ХХК	15	Жуулчин Дюти Фрий ХК
8	Жуулчин ХХК	16	Таван Богд Констракшн Машинери ХХК

2. Таван Богд Группийн хөрөнгө оруулалттай компаниуд

Д/д	Компанийн нэрс	Д/д	Компанийн нэрс
1	Хаан Банк ХК		

3. Бусад холбоотой талууд

Д/д	Компанийн нэрс	Д/д	Компанийн нэрс
1	Ар И Ди Эженси ХХК	3	Энэвэ Стори ХХК
2	Глобал Бридж ХХК		

4. Говь ХК-ийн охин компани, салбарууд

Д/д	Охин компанийн нэрс	Д/д	Охин компани, салбарын нэрс
1	Гоёо ХХК	5	Говь Кашмер Их Британи ХХК
2	Говь Кашмер Европ ХХК	6	Говь Кашмер Казахстан ХХК
3	Говь Кашмер Өвөр Монгол ХХК	7	Говь Кашмер Солонгос ХХК
4	Говь Кашмер Америк ХХК	8	Говь Австрали /салбар/